



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 07

Хэрлэн сум

Санал уламжлах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.8, 3.8.2-т заасныг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн саналыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны дөрөвдүгээр хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын төрийн албанд ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, 2021 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзан үзэж дэс түшмэлийн ангиллын 7, туслах түшмэлийн ангиллын 3 албан хаагчдад зэрэг дэвийг ахиулан, туслах түшмэлийн ангиллын 1 албан хаагчдад зэрэг дэвийг шинээр олгуулах саналыг хавсралтад дурдсанаар аймгийн Засаг дарга /Ц.Чогсомжав/-д уламжилсугай.

2. Энэхүү тогтоолыг аймгийн Засаг даргад өргөн мэдүүлж зэрэг дэв олгуулах асуудлыг шийдвэрлүүлж, гарсан шийдвэрийг холбогдох газар, байгууллагуудад хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

Төрийн албаны зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 2-сарын 1-ны өдрийн Дугаар тогтоолын хавсралт

ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН ЖАГСААЛТ

Зэрэг дэв ахиулан олгох

№	Овог, нэр	Албан тушаал	Төрийн албанд ажилласан жил	Тухайн албан тушаалд ажилласан жил	Зэрэг дэвийн санал		Үнэлгээ	Сахилгын шийтгэлтэй эсэх	Олгосон зэрэг дэв
					Одоогийн зэрэг дэв	Олгуулахаар санал болгосон зэрэг дэв			
Дэс түшмэл									
1	Ханджав Байгалмаа	Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын Анхан шатны боловсрол хариуцсан мэргэжилтэн	20	8	Гутгаар зэрэг Дэс түшмэл 2020 оны Б/10	Дэд зэрэг Дэс түшмэл	сайн 86.6	үгүй	Дэд зэрэг Дэс түшмэл
2	Цогт-Очир Түвшинхүү	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор	13	4	Гутгаар зэрэг дэс түшмэл 2020 оны Б/10	Дэд зэрэг дэс түшмэл	маш сайн 95.7	үгүй	Дэд зэрэг дэс түшмэл
3	Сорогжоо Жав	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор	29	8	Дэд зэрэг Дэс түшмэл 2019 оны Б/25	Тэргүүн зэрэг Дэс түшмэл	маш сайн 95.7	үгүй	Тэргүүн зэрэг Дэс түшмэл
4	Дорж Пүрэвжав	Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор	17.8	5.3	Гутгаар зэрэг Дэс түшмэл 2019 оны Б/25	Дэд зэрэг Дэс түшмэл	маш сайн 92.7	үгүй	Дэд зэрэг Дэс түшмэл
5	Болд Алдармаа	Онон-Балжийн байгалын цогцолборт газрын хамгаалалтын захиргааны ахлах мэргэжилтэн	10	8	Гутгаар зэрэг дэс түшмэл 2020 оны Б/10	Дэд зэрэг Дэс түшмэл	маш сайн 95	үгүй	Дэд зэрэг Дэс түшмэл

6	Пүрэв Гансүх	Онон-Балжийн байгалын цогцолборт газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн	24	9	Дэд зэрэг дэс түшмэл 2020 оны Б/10	Тэргүүн зэрэг дэс түшмэл	маш сайн 90.8	үгүй	Тэргүүн зэрэг дэс түшмэл
7	Оросоо Дашдаваа	Онон-Балжийн байгалын цогцолборт газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн	10	2	Дөтгөөр зэрэг дэс түшмэл 2016 оны Б/08	Гутгаар зэрэг дэс түшмэл	сайн 88,9	үгүй	Гутгаар зэрэг дэс түшмэл
Туслах түшмэл									

1	Цэвээндорж Баярмагнай	Онон-Балжийн байгалын цогцолборт газрын хамгаалалтын захиргааны Байгаль хамгаалагч	15	9	Гутгаар зэрэг Туслах түшмэл 2020 оны Б/10	Дэд зэрэг Туслах түшмэл	маш сайн 90.4	үгүй	Дэд зэрэг Туслах түшмэл
2	Жамц Ганзориг	Онон-Балжийн байгалын цогцолборт газрын хамгаалалтын захиргааны Байгаль хамгаалагч	20	12	Гутгаар зэрэг Туслах түшмэл 2015 оны Б/25	Дэд зэрэг Туслах түшмэл	сайн 83.1	үгүй	Дэд зэрэг Туслах түшмэл
3	Цэдэвдорж Онон	Онон-Балжийн байгалын цогцолборт газрын хамгаалалтын захиргааны Байгаль хамгаалагч	19	13	Дөтгөөр зэрэг Туслах түшмэл 2015 оны Б/25	Гутгаар зэрэг туслах түшмэл	сайн 80.5	үгүй	Гутгаар зэрэг туслах түшмэл

Шинээр олгох

№	Овог, нэр	Албан тушаал	Төрийн албанд ажигласан	Тухайн албан тушаалд ажигласан жил	Зэрэг дэвийн санал		Сахилгын шийтгэлтэй эсэх	Олгосон зэрэг дэв
					Одоогийн зэрэг дэв	Олгуулахаар санал болгосон зэрэг дэв		
Туслах түшмэл								
1	Болдбаатар Ган-од	Онон-Балжийн байгалын цогцолборт газрын хамгаалалтын захиргааны Байгаль хамгаалагч	9	2	*	Дөтгөөр зэрэг Туслах түшмэл	сайн 88.2	Дөтгөөр зэрэг Туслах түшмэл